



ЭМ ХАНГАМЖИЙН
БАЙГУУЛЛАГУУДАД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН
ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР**

Энхтайван найрамдлын ордон, Энхтайваны өргөн чөлөө,
3 дугаар хороо, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 01 82, Цахим шуудан: info@mmra.gov.mn,
Цахим хуудас: www.mmra.gov.mn

2026.06.05 № 01/890

танай _____ -нvi № _____ -т

Чиглэл хүргүүлэх тухай

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.13. Хангамжийн байгууллага энэ хуулийн 47.12-т заасан цахим мэдээллийн нэгдсэн санд эм, эмнэлгийн хэрэгслийн хамгийн бага хэмжих нэгж, түүний суурь үнэ, бөөний үнэ, жижиглэнгийн үнийг тухай бүр байршуулах үүрэгтэй заалт, мөн Улсын Их Хурлын 2024 оны 30, 38 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор эмийн нөөцийн мэдээлэл солилцох шаардлагатай байгаа тул 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн эцсийн үлдэгдлийг хавсралтын дагуу гаргаж, 2026 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн дотор ankhzaya@mmra.gov.mn цахим хаягаар ирүүлж хамтран ажиллана уу. Заасан хугацаанд мэдээллийг бүрэн, үнэн зөв ирүүлээгүй тохиолдолд Эм эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1-д заасны дагуу арга хэмжээ авахыг мэдэгдье.

Хувийг Нийслэлийн Эрүүл мэндийн газар, "Монголын эм зүйн байгууллагын нэгдсэн эм холбоо" ТББ, "Монголын эм хангамжийн байгууллагын холбоо" ТББ-д.

Хавсралт хуудастай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ *Т. Ариун* ДАЛТАНЦЭЦЭГ



